

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Б.СУХБАТЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин			Эхэлсэн дууссан хугацаа	Биелт хуу
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		
	1	2	3	4	5	6	7

Зорилт 4: Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх

1	Мэдээллийн нэгдсэн санд дүн шинжилгээ хийж, өгөгдлийг боловсруулсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Гаалийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг техник, сүлжээ болон программ хангамжийг боловсронгуй болгох, өгөгдлийн сан болон програм хангамжийн лицензийн шийдлийг судалж, санал боловсруулсан байна.	1. Гаалийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын техник, сүлжээ болон программ хангамжийг боловсронгуй болгох, өгөгдлийн сан болон програм хангамжийн лицензийн шийдлийг судалж, санал боловсруулах ажлын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд: - Дата төвийн сүлжээний дэд бүтэц анх 2009 онд сүлжээний дотоод дамжих дээд хурд 100Mebabit байхаар төлөвлөгдсөн ч одоог хүртэл хэрэглэж байгаа учир өгөгдлийн хэмжээ томорч, сүлжээ удаашрах гацалт доголдол үүсэж эрсдэлтэй байдалд хүрч байна. Иймээс дата төвийн сүлжээний бүтцийн тоног төхөөрөмжүүдийг шинэчилж сайжруулахаар Cisco, Fortinet компаниудын монголын зах зээлийг хариуцсан мэргэжилтнүүдтэй тус бүр цахим уулзалт хийж манай байгууллагад нийцтэй тоног төхөөрөмжийн шийдлийн талаарх санал солилцсон ба дата төвийн сүлжээний дэд бүтцийн логик план зургийг сүүлийн үеийн өндөр хурдны 25Gibabit/100Gibabit шилэн кабелийн төлөвлөлттэй байхаар судалгааг гарган Азийн хөржлийн банк, СХОГ-т хүргүүлсэн. - Өгөгдлийн агуулах(Data warehouse) бий болгох, цахим мэдээлэл солилцох (ESB), тайлан мэдээ дашбоард боловсруулах (Tableau) зэрэг програм хангамжийн лицензийн техникийн тодорхойлолтыг гаргаж, АХБ-н хүргүүлж худалдан авалтыг хийсэн. - Өгөгдлийн сан болон програм хангамжийн лицензийн шийдлийг судалж, КАИС системийн өгөгдлийн сангийн жил бүрийн лицензийн сунгалтын үнийн судалгааг хийсэн. - WWW.GAALIMN системд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирсэн хүсэлтийн дагуу бүртгэлийг үүсгэж,	01.01-11.30	10
---	--	-------------------------	---	--	---	-------------	----

				шаардлагатай мэдээ, мэдээллээр хангасан. Мөн тус систем дээр гарсан байгаа сервер тоног төхөөрөмжүүдэд гарч байгаа алдаа дутагдлыг тухай бүрд нь арилгаж ажилласан.		
				- Мэдээллийн аюулгүй байдлын газраас өгсөн зөвлөмж, болон гаалийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын журмын дагуу дата төв, гаалийн нэгдсэн сүлжээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг хийж, хүргүүлэн ажилласан. - ЦХХХЯ болон Үндэсний статистикийн хороо хамтран үндэсний хэмжээний нэгдсэн мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор "Их өгөгдлийн сан"-г үүсгэх, түүний суурь мэдээлэл болох "Мета өгөгдлийн платформ" байгуулахаар ажиллаж байна. Уг ажлын хүрээнд гаалийн байгууллагын экспорт, импортын мэдүүлэг, манифест, тээврийн хэрэгслийн бүртгэл зэрэг програмын өгөгдлийн сангийн талбарууд, ангилалын кодын мэдээллийг бэлтгэн хүргүүлж, Төрийн мета өгөгдлийн нэгдсэн сан http://metadata.app.nso.mn/-д байршуулсан.		
2	Мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, аюулгүй байдлыг хангах, тоног төхөөрөмжийн судалгаа хийсэн байдал.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Систем, сүлжээ, серверүүдэд мониторинг хийх, тасралтгүй хэвийн найдвартай ажиглагаа, нууцлал, хадгалалт, аюулгүй хамгаалалтын аюулгүй байдлыг хангасан байна. 2. Шаардлагатай тохиолдолд тоног, төхөөрөмжийн холбогдох судалгааг хийх, төлөвлөх, хуваарилах, ашиглалтад хяналт тавих, засвар үйлчилгээ хийнэ.	01.01-11.30	10

				Бүдүүлэлтийн цахим төв байрлаж байгаа байранд бүрэн засварын ажлын хийж, сүлжээний холболтыг хүлээн авч сүлжээний ДЭД бүтэц дээр суурилуулах тоног төхөөрөмжийн тооцооллыг гаргаж шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн худалдан авалтын хийж төхөөрөмжүүдийг суурилуулж сүлжээний холболт тохиргоог хийж компьютер техник хэрэгсэлүүдийг угсарч нэг бүрчлэн сүлжээнд холбон бүрдүүлэлтийн цахим төвийг хэвийн ажиллагаанд оруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.	
				2. Дата төвийн өргөтгөл шинэчлэл, хэвийн найдвартай ажиллагааг хангах ажлын хүрээнд:	
				- Мэдээллийн аюулгүй байдлын газраас Гаалийн байгууллагын дата төвийн систем сүлжээний орчинд Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг хийж, зөвлөмжийг ирүүлсэн. - Мэдээллийн технологи, мэдээллийн аюулгүй байдлын бодлого, дүрэм, журам, төлөвлөгт, орчны аюулгүй байдал; - Системийн аюулгүй байдал; - Сүлжээний аюулгүй байдал; - Программ хангамжийн аюулгүй байдал; - Серверийн ерөөний аюулгүй байдал; - Өгөгдлийн сангийн нөөцлөгт аюулгүй байдал - Гаалийн байгууллагад ирүүлсэн зөвлөмжийн дагуу шаардлагатай тоног төхөөрөмж, системүүд дээр өөрчлөгт, тохиргоог хийж, тус газарлуу хариуг хүргүүлсэн. - Тус зөвлөмжийн дагуу гаалийн байгууллагын дата төвийн үндсэн сүлжээний тоног төхөөрөмж болон бусад шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг шинэчлэн сайжруулах зөвлөмж өгсөний дагуу гаалийн байгууллагын зүгээс шаардлагатай төхөөрөмжүүдийн худалдан авч, суурилуулж, ажиллагаанд оруулж, тохиргоог хийн ажиллаж байна. - Дата төвийн өдөр тутмын хэвийн найдвартай ажиллагааг хангах үүднээс тоног төхөөрөмжүүдийн найдвартай байдлыг шалгаж, ажиллагааг хянан ажиллаж байна. - Дата төвийн хөргөлтийн төхөөрөмжид гарсан техникийн гэмтлийг цаг тухайд нь яаралтай арга хэмжээ авч оношлон эвдрэлтэй сэлбэг хэрэгслийн судалгааг хийж удирдлагуудад танилцуулан, шаардлагатай эд анги сэлбэгүүдийг шинээр худалдан авч нийлүүлэгч компаниар засвар үйлчилгээг хийлгэсэн.	

				сүлжээ компани, Мобиком ХХК, Скаймедиа ХХК-ийн станцтай холбосон шилэн кабель, дамжуулах тоног төхөөрөмжид гарсан гэмтлийг цаг алдалгүй засварлаж хилийн үйл ажиллагааг хэвийн ажиллагааг хангаж ажилласан. - Шивээхүрэн, УБГТ, Завхан ГХ, Хөвсгөл ГХ, Гашуунсүхайт ГТ, Ханги ГТ, Бургастай Боомт, Эрээнцав боомт, Цагааннуур боомт зэрэг газруудад гарсан сүлжээний гэмтэл саатал, тасралт, бусад газар хороодоос ирсэн сүлжээний дуудлагуудыг 24 цагийн турш цаг тухайд нь шалгаж гэмтлүүдийг тогтоон засварлаж, сүлжээний тохиороонуудыг хийж, хэвийн ажиллагаанд оруулж, үйл ажиллагааг тасралтгүй явуулах нөхцөл бололцоог хангаж ажилласан. - Гашуунсүхайт ГТ, Ханги дахь ГТ, УХШИГТ, БӨГТ, СШГТ-уудад хяналтын бүсээр зарлагдсан талбайг гаалийн байгууллагын нэгдсэн сүлжээнд холбох холболтыг хийж, шуурхай удирдлагын төвөөс тус гаалийн газрын харьяа гаалийн хяналтын бүс, баталгаат агуулах, татваргүй барааны дэлгүүрүүдийн төлөхяналтын камерыг хянах нөхцөл бололцоог хангаж ажилласан. Мөн ажиллаж байгаа гаалийн хяналтын бүс талбай, татваргүй барааны дэлгүүр зэрэг газруудаас ирсэн дуудлагыг хүлээн авч шалгаж, заавар зөвлөгөөг өгсөн. - Гаалийн байгууллагын төрийн цахим хуудсыг шинэчилж сайжруулах ажлын хүрээнд шинээр нэвтрүүлж байгаа цахим хуудсыг /customs.gov.mn/ үндэсний дата төвийн түрээсийн хийсвэр сервер дээр байршуулах явцад маш ихээр удах, гацах, зарим тохиолдолд шинээр байршуулсан цахим хуудас бүрэн ачааллаж гарч ирэхгүй байх, ердөө 1 цахим хуудас байршуулахад бүтэн 3~5 ажлын өдөр зарцуулж байгаа нь бидний шаардлагад нийцэхгүй байгаа тул үндэсний дата төвд хүсэлт тавьж гаалийн байгууллагын өөрийн сервер дээр нүүлгэн шинээр ажиллах орчин бэлдэн байршуулж ажиллуулсан бөгөөд гаалийн газар 19 хороо тус бүрд цахим хуудсыг байршуулахад хамгийн ихдээ 20~40 минутанд хуулж байршуулдаг болсон ба тус системийг өөрийн дата төвд байршуулах нь нөөцлөгт архивыг өдөр тутам хийж болдог болсон. - Бүрдүүлэлтийн цахим төвийн засварын ажил дууссан тул хэрэглэгчийн сүлжээг шалгаж хэвийн ажиллагаанд оруулсан. Тус газрын сүлжээг ГЕГ-ын сүлжээнд шинээр зохион байгуулж, 60 хэрэглэгчийг сүлжээнд холбож, хэвийн найдвартай ажиллагааг ханган ажилласан. Мөн	
--	--	--	--	--	--

				• 2024 оны 7 сард дата төвийн хөрөлтийн төхөөрөмжинд гарсан томоохон хэмжээний эвдрэлээс үүдэн дата төв 7 цагийн турш бүрэн зогсож эх хавтан, удирдлагын хэлхээнд гарсан гэмтлийг мэргэжлийн байгууллагатай хамтран засварлаж хөрөлтийн тоног төхөөрөмжүүдийг 8 цагийн дараа засварлаж дуусан хэвийн ажиллагаанд оруулж ажилласан. • Дата төвд шинээр суурилуулах хөрөлтийн төхөөрөмжийн худалдан авалтыг хийж 2024 оны 8 сард дата төвд шинэ хөрөлтийн төхөөрөмжийг суурилуулах бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд хуучин ашиглах боломжгүй болсон хөрөлтийн төхөөрөмжийг задгалж буулган оронд нь шинэ 2 ширхэг төхөөрөмжүүдийг байрлуулах суурыг бэлтгэж шинэ төхөөрөмжүүдээ суурилуулж, угсарч, холболт тохиргоог хийж бүрэн ажиллагаанд оруулсан. • Дата төвийг аваарын үед тэжээлээр хангах зориулалттай нөөц дизель станцын техникийн ээлжит урсгалд засвар үйлчилгээг хийж бэлэн байдлыг ханган, өдөр тутмын хяналтыг хийсэн. • ГЕГ болон бусад гаалийн газар хороодын цахим хуудсыг өөрсдийн сервер лүү зөөх, мөн стандартыг хангасан шинэ загварыг тус бүрийн домайн хаяг дээр суулгаж хариуцсан ажилтануудад Админ эрхийг нээж өгсөн бөгөөд заавар зөвлөгөөг тогтмол өгч хэвийн найдвартай ажиллагааг ханган ажиллаж байна. 3. Шаардлагатай тохиолдолд тоног, төхөөрөмжийн холбогдох судалгааг хийх, төлөвлөх, хуваарилах, ашиглалтад хяналт тавих, засвар үйлчилгээ хийх • Замын-Ууд боомтын ачаа тээврийн шинэ шалган нэвтрүүлэх цогцолбор ашиглалтад оруулахтай холбогдуулан тус боомтын сүлжээний дотоод зохион байгуулалтыг шинэчлэн, хилийн хяналтын байгууллагуудаас тусгаарлан шинэ сүлжээний дэд бүтцийг шинээр хийж дуусган сүлжээний төхөөрөмжүүдийг суурилуулж холболт, тохиргоог хийж, тус боомтын шинэ цогцолборын барилгыг ашиглалтад оруулсан. • ГЕГ-ын ЗББНДБ-уудын компьютер, техник тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах ажлын хүрээнд дараах засвар үйлчилгээг хийж, хэвийн найдвартай байдлыг ханган ажилласан. - Албан хаагчдын компьютеруудын дагалдах тоног төхөөрөмж болон сүлжээний тохиргоо, засвар үйлчилгээг - 325
--	--	--	--	--

				- Албан хаагчдын ашиглаж буй компьютерийн хэрэглээний програм суурилуулах – 132 дуудлага - Принтер хувилах төхөөрөмжид тохиргоо засвар үйлчилгээг хийсэн – 140 дуудлага - Дотоод сүлжээний холболт, гэмтэлтэй холбоотой - 215 дуудлага - Гаалийн газар хороодоос компьютер техник хэрэгсэлтэй холбоотой 289 дуудлага хүлээн авч онлайнаар заавар зөвлөгөө өгсөнөөс системийн гэмтэл 61, программын тохиргоо 69, принтерийн тохиргоо 42 дуудлагын засвар үйлчилгээг хийж, заавар зөвлөгөөг өгч ажилласан. - Системийн хэмжээнд 800 албан хаагчдын компьютерт вирусийн эсрэг ESET програмыг суулгасан. Гаалийн байгууллагын сүлжээний дэд бүтцийг сайжруулах зорилгоор дата төвд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн шинэчлэх ажлыг 2024-11-25наас 2024-11-26ны өдрийг дуустал зохион байгуулсан. Гаалийн систем сүлжээг 24 цаг зогсоож, хуучин ашиглаж байсан 8 тоног төхөөрөмжийг салгаж, сүлжээний 12, сервер 2, нийт 32 тоног төхөөрөмжийг шинээр суурилуулсан. Гаалийн 21 газар хороод болон 160 хяналтын бус, баталгаат агуулах, чөлөөт бусуудийн сүлжээний тохиргоог шинэчлэн хийж хэвийн ажиллагаанд оруулсан. Уг ажлыг МТГ-ын 8 албан хаагч 40 цаг турш ажиллан, үр дүнтэйгээр шинэчлэсэн.		
3	Албан хаагчдын чадавхыг бэхжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Гаалийн ерөнхий газрын Мэдээллийн технологийн асуудал хариуцсан албан хаагчдыг мэдээллийн технологийн чиглэлээр чадавхжуулах боломжийг хангаж ажилласан байна. • Мэдээллийн технологийн асуудал хариуцсан албан хаагчдыг мэдээллийн технологийн чиглэлээр чадавхжуулах боломжийг хангах ажлын хүрээнд: • Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТУГ-аас “Ази Номхон Далайн Бүсийн Сүлжээ Мэдээллийн Төв” (ARNIC) байгууллагатай хамтран 2024 оны 04 сарын 22-ны өдөр зохион байгуулсан Сүлжээний тоон шинжилгээний практик сургалтад хамрагдсан. • 2024.08.15ны өдөр Novelsoft ХХК-иас Mulesoft програмын сургалтад оролцсон.	01.01-11.30	10
4	Мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагаа, хамгаалалт, аюулгүй байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Гаалийн байгууллагын Мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагаа, нууцлал, хадгалалт, хамгаалалт,	01.01-11.30	10

			аюулгүй байдлыг хангаж ажилласан байна. 2.Гаалийн мэдээллийн системийг хөдөлгөөнт төхөөрөмжүүд дээр бүрэн ашиглах боломжийг бүрдүүлсэн байна. 3.Гаалийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын техник, сүлжээ болон программ хангамжийн судалсан шийдлийг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна. 4.Албан хаагчдыг ажлын компьютерээс албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах явдлыг хянах боломжийг бүрдүүлж, харьяа 18 гаалийн газар, хорооны албан хаагчдын компьютерыг нэгдсэн удирдлага менежментийн системд холбоно. Ингэснээр ажилтан, албан хаагчид мэдээллийг ямар зорилгоор системээс авч байгаад хяналт	
		• Үндэсний дата төвийн сервер дээр байрлаж байсан Гаалийн ерөнхий газрын болон газар хороодын үндсэн веб сайтуудыг гаалийн ерөнхий газрын дэргэдэх дата төвд зөөж холбогдох тохиргоог системийн админтай хамтран хийж аюулгүй байдал болон хурдан найдвартай ажиллагааг сайжруулж хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллаж байна.Гаалийн байгууллагын мэдээллийн нэгдсэн системд ашиглагдаж буй системийн өөрчлөлт, нэмэл хөгжүүлэлт болон засвар өөрчлөлтийг оруулахад тест серверт оруулж туршиж үзэн холбогдох нэгжийн зөвшөөрөлтэйгөөр системд өөрчлөлтүүдийг оруулж байгаа. • Засгийн газрын 2018 оны 30 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу "Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбогдох төрийн байгууллага болон төрийн өмчит хуулийн этгээдийн жагсаалт"-д багтсан байгууллагуудад шаардлага ирүүлсний дагуу гаалийн системийн хэмжээнд ашигладаг интернэтийн урсгалын гарах гарцыг Тагнуулын ерөнхий газрын мэдээллийн аюулгүй байдлын газрын "ТӨРИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СҮЛЖЭЭ"-нд холбож аливаа халдлагын улмаас учирч болох эрсдэлээс давахар хамгаалагдсан. • Гаалийн байгууллагад ашиглагдаж байгаа үндсэн систем КАЙС, СЕРР болон цахим шуудан, edos.ecustoms.mn, чат гэх мэт эрхийг нээх хаах, нууц үг сэргээх ажлыг тухай бүр шийдэж ажилласан. 2. Гаалийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын техник, сүлжээ болон программ хангамжийн судалсан шийдлийг үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байна. • Дата төвийн сүлжээний дэд бүтэц анх 2009 онд сүлжээний дотоод дамжих дээд хурд 100Megabit байхаар төлөвлөгдсөн ч одоог хүртэл хэрэглэж байгаа учир өгөгдлийн хэмжээ томорч, сүлжээ удаашрах гацалт доголдол үүсэж эрсдэлтэй байдалд хүрч байна. Иймээс дата төвийн сүлжээний бүтцийн тоног төхөөрөмжүүдийг шинэчилж сайжруулахаар Cisco, Fortinet компаниудын монголын зах зээлийг хариуцсан мэргэжилтнүүдтэй тус бүр цахим уулзалт хийж манай байгууллагад нийцтэй тоног төхөөрөмжийн шийдлийн талаарх санал солилцсон ба дата төвийн сүлжээний дэд бүтцийн логик план зургийг сүүлийн үеийн өндөр хурдны 25Gigabit/100Gigabit шилэн кабелийн төлөвлөлттэй байхаар судалгааг гарган Азийн хөгжлийн банк, СХОГ-т хүргүүлсэн. Тус хүсэлтийн дагуу дата төвийн үндсэн дэд бүтцийн сүлжээ болон хамгаалалтын төхөөрөмж "Firewall" тоног төхөөрөмж		

тавих бүрдэнэ	боломж	хуудалдан авч, хуучин тоног төхөөрөмжүүдийн шинэчлэн сайжруулж, ажиллагаанд оруулсан. Тус тоног төхөөрөмжийг ажиллагаанд оруулснаар Дата төвийн дотоод болон гадаад хурд нь 1000 дахин нэмэгдэж систем хооронд мэдээлэл дамжуулах, гадаад урсгалын аюулгүй байдлыг бүрэн хангах тоног төхөөрөмжүүдийг суурилуулж ажиллагаанд оруулан ажиллаж байна. • Газар хороодын телехяналтын тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах тог тогтворжуулагч гэмтлийг тодорхойлж, засварлуулах боломжгүй төхөөрөмжийн судалгааг хийж, СХОГ хүргүүлэн ажилласан. • Газар хороодод ашиглаж байгаа сүлжээ, сервер бусад дагалдах тоног төхөөрөмжүүдэд тогтмол хяналтыг тавьж, эвдрэл гэмтлийг тодорхойлж, шаардлагатай сэлбэг хэрэгслийн судалгааг хийж, ажилласан. • ГЕГ-ын газар, хэлтсийн хэрэгцээ шаардлагын дагуу шаардлагатай компьютер техник хэрэгсэл, сэлбэгийн судалгааг гаргаж ИТААҮА-д хүргүүлэн ажилласан. 3. Мэдээллийн аюулгүй байдлын газраас 2024.02.26-2024.03.01-ны хооронд Гаалийн байгууллагын нэгдсэн сүлжээ болон Дата төвд Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж, тайлан ирүүлсэн. МАБГ-аас ирсэн зөвлөмжийн дагуу систем болон сүлжээний тоног төхөөрөмжүүдээр тохиргоо хийж, зөвлөмжийн биелэлтийг ханган ажилласан. • МАБГ-аас өгсөн санамжийн дагуу КАИС системд ашиглаж буй JavaScript сангийн хувилбар хуучных байсан ба халдлагад өртөж болзошгүй гэсэн санамжийн дагуу тухайн санг сүүлийн хувилбараар шинэчилсэн. 4. Гаалийн мэдээллийн системийг хөдөлгөөнт төхөөрөмжүүд дээр ашиглах: • Тоон гарын үсэг ашиглаж буй ГУБ нар суурин компьютер бус хөдөлгөөнт төхөөрөмжөөс КАИС системд нэвтрэх шаардлагатай байдаг тул тухайн хөдөлгөөнт төхөөрөмжийг ашиглан КАИС системд нэвтрэхэд заавал тоон гарын үсэг шаардахгүй нэвтрэх нэр, нууц үгээр нэвтрэх боломжоор хангасан. • Харьга гаалийн газар хорооны албан хаагчдын компьютерыг нэгдсэн удирдлага менежментийн системд холбох ажлын хүрээнд ГГХ тус бүрийн 1 компьютерийг домайнд холбож, тус домайн эрхийг tableau програмд ашиглах боломжийг бүрдүүлсэн. Домайн эрхийг ГГХ-ын tableau хариуцсан ажилтанд хариуцуулан өгөхөөр ажиллаж байна.
------------------	--------	--

5	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож сан үүсгэн, түүнд дүн шинжилгээ хийж бууруулах арга хэмжээг авч ажиллана. 2. Бууруулсан эрсдэлийг санд бүртгэсэн талаар болон нэгжийн үйл ажиллагаанд учирсан ач холбогдол, үр дүнгийн талаар оновчтой тайлагнасан байна	Мэдээллийн технологийн (MT) салбарт эрсдэлийг удирдах нь байгууллагын үйл ажиллагааны найдвартай байдал, өрсөлдөх чадварыг хадгалахад чухал үүрэгтэй. Гаалийн байгууллагын мэдээллийн технологийн газрын эрсдэлийг тодорхойлох нь байгууллагын мэдээллийн системийн найдвартай байдал, аюулгүй ажиллагаа, үр ашигтай байдлыг хангах чухал үндэс суурь юм. Мэдээллийн технологийн эрсдэлд хамаарах хүчин зүйлс нь байгууллагын мэдээллийн систем, өгөгдөл, тоног төхөөрөмж, ажилтнууд болон гадаад орчны олон талт нөлөөнөөс шалтгаалж үүсэж боломжтой. MT-с үйл ажиллагаа, чиг үүргийг нарийвчлан судалж, байгууллагын мэдээллийн технологийн чиглэлд гарч болзошгүй дараах эрсдэлийн хүчин зүйлсийг тодорхойлсон. • Тоног төхөөрөмжийн эвдрэл • Сүлжээ, системийн тасалдал • Програм хангамжийн алд аа • Кибер халдлага • Мэдээллийн алдагдал • Мэргэшсэн ажилтны дутагдал • Сургалт, хөгжлийн дутагдал • Хүний нөөцийн тогтворгүй байдал • Байгалийн гамшиг • Төсвийн дутагдал Үнэлгээний аргачлал нь эрсдэл бүрийг магадлал (тохиолдох боломж) болон нөлөөллийн (тохиолдсон тохиолдолд үзүүлэх нөлөө) түвшинг тодорхойлж, эрсдэлийн матрицад байршуулсан. Эрсдэлийн матрицад байршуулсанаас харахад өндөр, дунд, бага эрсдэлд дараах хүчин зүйлс орсон бөгөөд эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө гаргасан. Тоног төхөөрөмжийн эвдрэл, сүлжээ тасалдал, төсвийн дутагдал зэрэг эрсдэлүүд байгууллагын үйл ажиллагаанд ноцтой нөлөө үзүүлэх тул яаралтай хяналт, шийдэл шаардлагатай. Технологийн шинэчлэл, мэргэшсэн ажилтны дутагдал зэрэг асуудлууд нь үйл ажиллагаанд зарим саад учруулж болох ч урт хугацаанд илүү том асуудал болж хувирах магадлалтай. Байгалийн гамшиг нь ховор тохиолддог ч тохиолдсон үед их хэмжээний нөлөө үзүүлдэг тул нөөц төлөвлөгөө шаардлагатай.	01.01-11.30	10
6	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Захиргааны зөвлөлийн хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, хуралдаан, хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн зөвлөлийн хуралдаан,	Захиргааны зөвлөлийн хуралдаан, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан, Онлайн, Шуурхайгаас болон бусад хэлбэрээр удирдлагаас өгөгдсөн 16 үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж, тухай бүр ЗДАС-ийн Үүрэг даалгаврын програмд оруулсан. Үүрэг даалгаврын төрлөөр нь ангилвал: - Үүрэг даалгавар 11 - Зөвлөмж 2	01.01-11.30	11

			Онлайн, Шуурхайгаас болон бусад хэлбэрээр удирдлагаас өгөгдсөн нийт үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж, тухай бүр тайлагнасан байна.	- Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан 1 - Онлайн хурлын даалгавар 1 - Ес зүйн дэд хорооны хуралдаан 1			
7	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг сайжруулж, цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид тогтмол бүртгүүлж, гадуур ажилласан, өвчтэй, чөлөөтэй тохиолдол бүрт СЕРП программаар тухай бүр илгээж ажилласан байна.	Тайлант хугацаанд ажлын өдрийн өглөө, орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид цагаа бүртгүүлж, нийт 11 хүсэлтийг тус тус Захиргаа дотоод ажлын системд тухай бүрт илгээж, хянуулсан. • Томилголтоор ажиллах 2; • Ээлжийн амралтын 2; • Акт 1; • Бусад 6;	01.01-11.30	100
8	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Стратеги 1.4.35.Автозамын хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэх/	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	1. Алтанбулаг боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 100%-д хүрч дуусна. Боомтын барилгын дотоод тохижилт, хаягжилт, тэмдэг, тэмдэглэгээ, тоноглол, гаалийн хяналт шалгалтын зарим тоног төхөөрөмжийг суурилуулж ашиглалтад хүлээж авах	Алтанбулаг боомт, Бичиг боомт, Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын ажил дуусаагүй учир тоног төхөөрөмжийг суурилуулах ажил хийгдээгүй хүлээгдэж байна.	01.01-11.30	100

			ажлыг зохион байгуулсан байна. 2. Бичигт боомтын бүтээн байгуулалтын барилгын ажил 50%-д хүрсэн байна. 3. Шивээхүрэн боомтын бүтээн байгуулалтын барилгын ажлыг эхлүүлсэн байна.		
9	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.27 Цахим гарын үсгийг гаалийн байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх/	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Эхний хагас жилд: 1. Системийн хэмжээнд удирдлагууд, хяналт, шалгалт хийж буй гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч нарыг тоон гарын үсэгтэй болгож тоон гарын үсгийг гаалийн мэдээллийн систем рүү нэвтрэх, бичиг баримтыг үнэлэх, хяналт, шалгалт хийх, зөвшөөрөл өгөх үйлдлүүд болон гаалийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашигладаг болсон байна. Сүүлийн хагас жилд: 1. Төрийн болон төрийн бус байгууллагатай харилцахдаа тоон	01.01-11.30
			1. Системийн хэмжээнд удирдлагууд, хяналт, шалгалт хийж буй гаалийн улсын ахлах байцаагч, гаалийн улсын байцаагч нарыг тоон гарын үсэгтэй болгож тоон гарын үсгийг гаалийн мэдээллийн систем рүү нэвтрэх, бичиг баримтыг үнэлэх, хяналт, шалгалт хийх, зөвшөөрөл өгөх үйлдлүүд болон гаалийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд тоон гарын үсгийг ашиглах ажлын хүрээнд: • Гаалийн ерөнхий дэргэдэх бүрдүүлэлтийн цахим төвийн дарга болон ахлах байцаагч, байцаагч нарын нийт 47ш тоон гарын үсгийн хугацааг сунгаж шаралт хийж сайз системтэй холбосон бөгөөд мөн ЗҮГТ-ын дарга ахлах байцаагч нарын 121ш тоон гарын үсгийн 1 жилийн сунгалтыг тус гаалийн газарт томилолтоор ажиллан газар дээр шарж сайз системтэй холбон хүлээлгэн өгсөн байгаа. УБГТ-ын 140ш дарга ахлах байцаагч нарын тоон гарын үсгийн шарах ажил хийгдэж байна. Мөн Газар хороодын дарга нарын 14ш тоон гарын үсгийг шарж бэлэн болгосон тараах ажлыг хийж байна. • Гаалийн ерөнхий газрын дарга болон хэлтсийн дарга нарт тоон гарын үсгийн гэрчилгээ суулгаж авсан бөгөөд гаалийн үндсэн систем болох САIS системтэй холбож, хэрэглээнд нэвтрүүлсэн. • Замын-үүд дэх гаалийн газар, ЧХОУНБГТ, Сэлэнгэ аймаг дах гаалийн газар, УХШИГТ, ГЕГ-ын дэргэдэх БДШ газрын дарга, албаны дарга, ГУАБ, ГУБ нарт тоон гарын үсгийн гэрчилгээг 1 жилийн хугацаатай суулгаж хүлээлгэн өгсөн бөгөөд КАИС, СЕПС, СИМС систем рүү нэвтрэн хяналт шалгалтанд ашигладаг болсон. Нийт 540 тоон гарын үсгийн төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн. • Дорноговь аймгийн Замын-Үүд боомтын зорчигч тээврийн шалган нэвтрүүлэх цогцолборт ашиглаж байгаа ухаалаг гарцын системийн хэвийн ажиллагааг хангуулах, тоон		

				гарын ашиглаж байна	үсгийг эхэлсэн	- гарын үсгийг нэвтрүүлэх, сургалт зохион байгуулахаар 2024.03.21-03.25-ны өдрийг дуустал 5 хоногийн хугацаанд дарга Б.Ганзориг, ГУАБ Н.Сандуйсүрэн, ГУБ Л.Доломжав, П.Хорлоо нар томилолтоор ажилласан. - Сэлэнгэ аймаг дахь гаалийн газрын албан хаагчдын тоон гарын үсгийг нэвтрүүлэх, чөлөөт бүсийн зорчигчийн бараа бүртгэлийн бар код хэвлэгчийг шалгах програмын түвшний тест хийх, сүлжээний тоног төхөөрөмжийн хэвийн, найдвартай ажиллагааг хангахаар ГУБ Л.Хорлоо, М.Оргил нар 2024.03.05-03.07-ны өдрийг хүртэл 4 хоногийн хугацаанд томилолтоор ажилласан. - УБГГ-ын 140ш тоон гарын үсгийн материалыг хүлээн авч нягтлах ажил хийгдэж дууссан бөгөөд шаралтын ажил хийгдэж байна 2024.12.25ны өдрөөс кайс, системтэй холболтыг хийж хэрэглээнд ашиглана.ГСГГ,ШХГГ-ын материалыг бүрдүүлэх ажил хийгдэж байна. - БДШГ-ын дарга болон ахлах,байцаагч нарын нийт 23 тоон гарын үсгийг шарж хүлээлгэн өгсөн бөгөөд алба хаагчдад цахим санд зөвхөн өөрийн эрхээр орж ажиллах бусад мэдээллийг нууцлалын түвшинд хадгалах хамгаалах, албан хэрэгцээнд ашиглаж байна. - Төрийн болон төрийн бус хувийн хэвшил ХХК байгууллагатай албан бичиг цахимаар солилцох ажлын хүрээнд ДОСХ дундын системтэй архив бичиг хэргийн систем болох ИДок систем гаалийн ерөнхий газар болох харьяа гаалийн 19 газар хороод бүрэн холбогдсон ба тус дундын системээр дамжуулан төрийн болон төрийн бус хувийн 4000 гаруй байгууллагуудтай тоон гарын үсэг ашиглан тоон гарын үсгээрээ баталгаажуулалт хийж цахимаар албан бичиг солилцохыг бүрэн нэвтрүүлсэн.		
--	--	--	--	---------------------	----------------	--	--	--


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Гүйцэтгэлийн түвшин		Эхэлсэн дууссан хугацаа	Бие
	1	2	3	4	Хүрсэн түвшин (Биелэлт)		5	х
							6	

1	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	Хүрсэн түвшингээр	-	Байгууллагаас зохион байгуулж байгаа сургалтууд, гаалийн хууль, журамруудыг уншиж судлан мэдлэгээ бататгасан.	Гаалийн ерөнхий газраас 7 хоног бүрийн 5 дахь өдөр зохион байгуулдаг Мэдээллийн цагт хамрагдсан.	05.14-11.30	10
2	Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх	Хүрсэн түвшингээр	-	Өмнөх жилүүд ажлын онцлоос шалтгаалж онлайн цахим хичээлүүдийг сонгон суралцаж анхан шатны мэдлэгээ бататгаж чадсан	Англи хэлний онлайн сургалтад сууж бие даан хэлний мэдлэгээ сайжруулсан.	01.01-11.30	10

ТАЙЛАН ГАРГАСАН:

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ



/Б.СУХБАТ/

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

**ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Б.СҮХБАТЫН 2024 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Мэдээллийн технологийн газар

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх" зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Мэдээллийн нэгдсэн санд дүн шинжилгээ хийж, өгөгдлийг боловсруулсан байдал	55	8	63	
2.	Мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгох, аюулгүй байдлыг хангах, тоног төхөөржмийн судалгаа хийсэн байдал.	59	10	69	
3.	Мэдээллийн нэгдсэн системийн үйл ажиллагаа, хамгаалалт, аюулгүй байдал	60	10	70	
4.	Албан хаагчдын чадавхыг бэхжүүлсэн байдал	57	8	65	
5.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	57	8	65	
6.	Үүрэг даалгаврын биелэлт	60	9	69	
7.	Ажлын цаг ашиглалт	58	10	68	
8.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /Стратеги 1.4.35.Автозамын хилийн боомтуудын хилээр нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлж, дэд бүтцийг өргөтгөн шинэчлэх/	55	8	63	
9.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт /1.4.27 Цахим гарын үсгийг гаалийн байгууллагын хэмжээнд нэвтрүүлэх/	55	5	60	

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх	80	12	
2.	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдахаар / төрийн албаны сургалтын байгууллага / болсон тохиолдолд 1 арга хэмжээ,	80	12	
Дундаж оноо:			12	

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Асуудал шийдвэрлэх	7	
3.	Хариуцлагатай байдал	7	
4.	Дүн шинжилгээ хийх	7	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Дундаж оноо:		7	

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	7
3.	Харилцаа	8
Дундаж оноо: 7.6		

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн
-----	---------------------	---------------------

		ОНОО
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	65.7
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	12
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7.6
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ))- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		92.3

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Мэдээллийн технологийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

.....

(Б.Ганзориг)

2024-12-10 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

зөвшөөрсөн:

Гаалийн улсын байцаагч

.....

(Б.Сүхбат)

2024-12-10 (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

.....

(Г.Энхтайван)

12/20, 2024 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн Гаалийн улсын ахлах байцаагч

.....

(Ө.Тэгшээ)


2024.12.20

.....(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч

Гаалийн ерөнхий газрын дарга



.....

(Р.Отгонжаргал)

.....(огноо)